



**"АДУУНЧУЛУУН" ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2021 оны 05 сарын 24 өдөр

Дугаар 21/04

Чойбалсан хот

**Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг
сонгох тухай**

Монгол улсын Компанийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1, "Адуунчулуун" ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.30 дахь заалт, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн (цаашид "ТУЗ" гэх) Үйл ажиллагааны журмын 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалт, ТУЗ-ийн 2021 оны 05 дугаар сарын 24-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн даргаар Баттогтохын Шатарыг сонгосугай.
2. Монгол улсын Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, болон бусад холбогдох хууль тогтоомжууд, Компанийн дүрэм, ТУЗ-ийн Үйл ажиллагааны журмыг мөрдөж ажиллахыг ТУЗ-ийн дарга /Б.Шатар/-д үүрэг болгосугай.
3. ТУЗ-ийн дарга сонгогдсон талаарх мэдээллийг Компанийн болон Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлж, Хөрөнгийн биржийн цахим хуудас дахь мэдээлэлд холбогдох өөрчлөлт хийхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /О.Гангамөрөн/-д үүрэг болгосугай.

ГИШҮҮД:



Ө.АМАРЖАРГАЛ

С.БАДАРЧ

Б.БАТСАЙХАН

Ш.БАЯСГАЛАН

Н.ВОЛДРАГЧАА

Д.ГАЛТОГТОХ

Ш.ИДЭР

Н.ЭНХЦЭЦЭГ



**“АДУУНЧУЛУУН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2021 оны 05 сарын 24 өдөр

Дугаар 21/05

Чойбалсан хот

**Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын
бүрэлдэхүүнийг батлах тухай**

Монгол улсын Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.2, “Адуунчулуун” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.46, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн Үйл ажиллагааны журмын 10 дугаар зүйлийн 10.1, 10.2, 10.3 дахь заалт, ТУЗ-ийн 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүнийг дор дурдсанаар баталсугай. Үүнд:

а. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо:

Хорооны дарга: Өлзийхутаг АМАРЖАРГАЛ
Гишүүд: Санжаа БАДАРЧ
Баттогтох БАТСАЙХАН
Шатар ИДЭР
Нанзаддорж ЭНХЦЭЦЭГ

б. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хороо:

Хорооны дарга: Санжаа БАДАРЧ
Гишүүд: Намжилцэрэн БОЛДРАГЧАА
Доржсүрэн ГАЛТОГТОХ
Өлзийхутаг АМАРЖАРГАЛ
Шатар БАЯСГАЛАН

в. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Цалин, урамшууллын хороо:

Хорооны дарга: Нанзаддорж ЭНХЦЭЦЭГ
Гишүүд: Санжаа БАДАРЧ
Доржсүрэн ГАЛТОГТОХ
Шатар ИДЭР
Шатар БАЯСГАЛАН

2. Монгол улсын Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжууд, Компанийн дүрэм, ТУЗ-ийн Үйл ажиллагааны журам, ТУЗ-ийн дэргэдэх хороодын журмуудыг мөрдөж, хорооны жилийн төлөвлөгөөг ТУЗ-ийн 06 дугаар сарын хуралд танилцуулахыг хороодын дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

3. ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүн томилогдсон талаарх мэдээллийг Компанийн болон Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /О.Гангамөрөн/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Б.ШАТАР



**"АДУУНЧУЛУУН" ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2021 оны 05 сарын 24 өдөр

Дугаар 21/06

Чойбалсан хот

**Төлөөлөн Удирдах зөвлөлийн Нарийн
бичгийн даргыг улируулан томилох тухай**

Монгол улсын Компанийн тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1, "Адуунчулуун" ХК (цаашид "Компани" гэх)-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.53, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид "ТУЗ" гэх)-ийн Үйл ажиллагааны журмын 2 дугаар зүйлийн 2.5.9, ТУЗ-ийн Даргын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн санал, ТУЗ-ийн 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн даргаар Ойдовжамцын Гангамөрөнг улируулан томилсугай.
2. Монгол улсын Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжууд, Компанийн дүрэм, ТУЗ-ийн Үйл ажиллагааны журам, Компанийн холбогдох бусад журмыг мөрдөж ажиллахыг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /О.Гангамөрөн/-д үүрэг болгосугай.
3. ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга томилогдсон талаарх мэдээллийг Компанийн болон Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлж, Хөрөнгийн биржийн цахим хуудас дахь мэдээлэлд холбогдох өөрчлөлт хийхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /О.Гангамөрөн/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Б.ШАТАР



**“АДУУНЧУЛУУН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2021 оны 05 сарын 24 өдөр

Дугаар 1107

Чойбалсан хот

**Төлөөлөн удирдах зөвлөлийн
2021 оны ээлжит хурлын хуваарь
батлах тухай**

Монгол улсын Компанийн тухай хуулийн 80 дугаар зүйл, “Адуунчулуун” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 7 дугаар зүйл, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн Үйл ажиллагааны журмын 8 дугаар зүйл, ТУЗ-ийн 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн ТУЗ-ийн 2021 оны ээлжит хурлын хуваарийг энэхүү тогтоолын Хавсралтаар баталсугай.
2. Энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт заасны дагуу Компанийн ТУЗ-ийн ээлжит хурлыг тогтоосон хугацаанд хуралдуулах ажлыг зохион байгуулж ажиллахыг ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга /О.Гангамөрөн/-д, түүнд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн дарга /Б.Шатар/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Б.ШАТАР

"Адуунчулуун" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 21/07 тоот тогтоолын ХАВСРАЛТ



**"АДУУНЧУЛУУН" ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
2021 ОНЫ ЭЭЛЖИТ ХУРЛЫН ХУВААРЬ**

№	ТУЗ-ийн ээлжит хурал	Огноо	Гариг
1	II улирлын ээлжит хурал	2021 оны 07 сарын 20	Мягмар
2	III улирлын ээлжит хурал	2021 оны 10 сарын 22	Баасан
3	IV улирлын ээлжит хурал	2021 оны 12 сарын 17	Баасан
4	2021 оны жилийн эцсийн хурал	2022 оны 02 сарын 10	Даваа